

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Улс: Монгол
Захиалагч: Зам, тээврийн яам
Төслийн нэр: Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл (P174806)
Гэрээний нэр: Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын 14.7км авто замын барилгын ажил
Тендерийн дугаар: ДӨТ(МОН) - ЗТЯ/20250801056
Зарласан хугацаа: 2025 оны 07 дугаар сарын 29 өдөр

- Монгол Улсын Засгийн газар нь “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл” (P174806)-ийг хэрэгжүүлэх зорилгоор Дэлхийн банкнаас санхүүжилт авч байгаа ба энэхүү санхүүжилтийн тодорхой хувийг төслийн хүрээнд хэрэгжих зам барилгын ажлын Багц 6 буюу “Өвөрхангай аймгийн Есөнзүйл сум чиглэлийн 14.7 км авто зам барих”-д заруулахаар төлөвлөсөн болно.
- Зам, тээврийн яам нь эрх бүхий тендерт оролцогчдоос дараах төслийн замд битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Үүнд:

Гэрээний дугаар	Гэрээний нэр	Гэрээний тодорхойлолт	Гэрээний хугацаа
Багц 6	Өвөрхангай аймгийн Есөнзүйл сум чиглэлийн 14.7 км авто зам барих	Ус зайлуулах хоолой, газар шорооны ажил, суурь, хучилтын ажлыг хамруулсан 14.7 км асфальтбетон хучилттай авто зам	Барилгын ажлыг хэрэгжүүлэх хугацаа: 24 сар, Баталгаат засварын хугацаа: 36 сар

- Тендер шалгаруулалтыг Дэлхийн Банкны “Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт (IPF)-ийн зээлдэгчэд зориулсан худалдан авах ажиллагааны журам” (2020 оны 11 дүгээр сар)-д заасан нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулна. Энэхүү тендер нь Худалдан авах ажиллагааны удирдамжид тодорхойлсон шаардлага хангасан бүх оролцогчдод нээлттэй байна. Түүнчлэн Дэлхийн банкны ашиг сонирхлын зөрчлийн талаар баримтлах бодлогын 1.6 болон 1.7-р заалтыг анхааран үзнэ үү.
- Сонирхсон эрх бүхий тендерт оролцогч нь ажлын өдрийн Улаанбаатарын цагаар 09:00 – 17:00 цагийн хооронд энэхүү урилгын төгсгөлд заасан хаягт хүрэлцэн ирж Зам, тээврийн яамнаас нэмэлт мэдээлэл авах, тендерийн баримт бичигтэй танилцах боломжтой.
- Сонирхсон тендерт оролцогч нь урилгын төгсгөлд заасан хаягт хандан бичгээр хүсэлтээ гаргаж, хоёр зуун тавин мянган (250,000.0) төгрөгийн дүнтэй хураамжийг эргэн үл төлөгдөх нөхцөлтэйгөөр төлсөнөөр тендерийн баримт бичгийг худалдан авч болно. Төлбөр төлөх арга: Дараах дансанд төлбөрийг шилжүүлнэ. Үүнд:

Дансны дугаар: MN 060090 1019000 11855

Банкны нэр: Төрийн банк (Төрийн сан)

Дансны нэр: Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл, Төсөл хэрэгжүүлэх нэгж

Баримт бичгийг цахим шуудангаар илгээнэ.

6. Тендерийг **2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 14:00 цагт** эсхүл түүнээс өмнө доорх хаягаар ирүүлнэ. Тендерийг цахимаар хүлээж авахгүй. Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана. Тендерийг **2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 15:00 цагт** доор заасан хаягаар хүрэлцэн ирж, нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.
7. Тендерийн хамт **150,000,000.00 (зуун тавин сая)** төгрөгийн үнийн дүнтэй **“Тендерийн баталгаа”-г** ирүүлнэ.
8. Дээр дурдсан хаяг нь:

Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Л.Баянзул

Засгийн газрын 13-р байр, Чингисийн өргөн чөлөө 11, Улаанбаатар хот 14251, Монгол Улс

Утас: (976)-51263179

Факс: (976)-11-312315

Майл хаяг: info@mrttd.gov.mn